

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2018 оны...дугаар  
сарын....-ны өдөр

Улаанбаатар хот

**ПАТЕНТЫН ТУХАЙ**  
/Шинэчилсэн найруулга/

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**  
**НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулж, шинийг санаачлах үйл ажиллагааг хөгжүүлэх, аж үйлдвэрийн хөгжлийг дэмжихэд оршино.

**2 дугаар зүйл.Патентын хууль тогтоомж**

2.1.Патентын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."патент" гэж шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар эзэмшигч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас олгож байгаа баримт бичгийг;

3.1.2.“шинэ бүтээл” гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах техникийн шийдлийг;

3.1.3.“ашигтай загвар” гэж бүтээц, хийцэд хамаарах техникийн шийдлийг;

3.1.4.“бүтээгдэхүүний загвар” гэж бүтээгдэхүүний гадаад харагдах байдалд хамаарах дүрс, хийц, хэлбэр, өнгө, бүтцийн болон хээ чимэглэлийн өвөрмөц онцлог шинжийг агуулсан уран сайхны шийдлийг;

3.1.5.“патентын мэдүүлэг” гэж оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдүүлэг гаргагчаас гаргаж байгаа хүсэлт, энэ хуульд заасан шаардлагын дагуу үйлдсэн мэдүүлэг болон бусад туслах баримт бичгийг;

3.1.6.“олон улсын мэдүүлэг” гэж Патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу гаргасан шинэ бүтээл, ашигтай загварын, эсхүл Гаагийн хэлэлцээрийн дагуу Дэлхийн

Оюуны Өмчийн Байгууллагын Олон Улсын Товчоонд гаргасан бүтээгдэхүүний загварын мэдүүлгийг;

3.1.7."мэдүүлэг гаргагч" гэж патентын мэдүүлгийг гаргаж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг;

3.1.8."зохион бүтээгч" гэж оюуны бүтээлч үйл ажиллагаагаар шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар зохион бүтээсэн хувь хүнийг;

3.1.9."патент эзэмшигч" гэж патент эзэмших онцгой эрхийг хуульд заасан журмын дагуу олж авсан хувь хүн, хуулийн этгээдийг;

3.1.10."мэдүүлгийн бүрдлийн шүүлт" гэж энэ хуулийн 22.9 дэх хэсэг болон 35 дугаар зүйлд заасан шаардлагыг тухайн патентын мэдүүлэг хангасан эсэхийг хянаж байгаа оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг;

3.1.11."анхдагч огноо" гэж энэ хуульд заасан шаардлага хангасан патентын мэдүүлгийг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн авсан, эсхүл Патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын Олон Улсын Товчоо хүлээн авсан он, сар, өдрийг;

3.1.12."давамгайлах огноо" гэж гэж мэдүүлгийнхээ анхдагч огнооноос өмнө Парисын конвенцын, эсхүл Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн аль нэг оронд гаргасан давамгайлах эрх үүсэх үндэслэл болсон Парисын конвенцын 4 дүгээр зүйлд заасан хугацаагаар тооцогдох нэг, эсхүл түүнээс дээш мэдүүлгийн он, сар, өдрийг;

3.1.13."мөн чанарын шүүлт" гэж энэ хуулийн 25, 26, 37 дугаар зүйлд заасан шаардлагыг тухайн патентын мэдүүлэг хангасан эсэхийг тогтоож, дүгнэлт гаргах оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг;

3.1.14."албан ёсны тогтмол хэвлэл" гэж Парисын конвенцын 12.2-т заасны дагуу шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын бүртгэлийн тухай мэдээллийг нийтэд мэдээлэх зорилгоор оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас өөрийн албан ёсны цахим хуудсанд тогтмол нийтлэх ном зүйн цахим мэдээллийг;

3.1.15."шинэ бүтээлийн ангилал" гэж Шинэ бүтээлийн олон улсын ангилал тогтоох тухай Страсбургийн хэлэлцээрээр 1971 оны 3 дугаар сарын 24-ний өдөр баталж, нэмэлт, өөрчлөлт оруулж, хянан засварласан "Патентын олон улсын ангилал"-ыг;

3.1.16."бүтээгдэхүүний загварын ангилал" гэж Бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал тогтоох тухай Локарногийн хэлэлцээрээр 1968 оны 10 дугаар сарын 8-нд баталж, нэмэлт, өөрчлөлт оруулж, хянан засварласан "Бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал"-ыг;

3.1.17."Парисын конвенц" гэж 1983 оны 3 дугаар сарын 20-ны өдөр баталж, нэмэлт, өөрчлөлт оруулж, хянан засварласан Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцыг;

3.1.18.“Патентын хамтын ажиллагааны гэрээ” гэж 1970 оны 6 сарын 19-ний өдөр Вашингтонд үйлдэж, нэмэлт, өөрчлөлт оруулж, хянан засварласан Патентын хамтын ажиллагааны гэрээг;

3.1.19.“Гаагийн хэлэлцээр” гэж 1960 оны 11 дугаар сарын 28-ны өдөр баталж, нэмэлт, өөрчлөлт оруулж, хянан засварласан Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай Гаагийн хэлэлцээрийг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ШИНЭ БҮТЭЭЛ, АШИГТАЙ ЗАГВАРЫН ПАТЕНТЫН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ**

### **4 дүгээр зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын хамгаалалт**

4.1.Шинэ бүтээл, ашигтай загварыг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас /цаашид “Оюуны өмчийн байгууллага” гэх/ энэ хуульд заасны дагуу олгосон патентаар хамгаална.

### **5 дугаар зүйл.Шинэ бүтээлийн патентаар хамгаалагдах зүйл, шалгуур**

5.1.Шинэ, шинэ бүтээлийн түвшин агуулсан, үйлдвэрлэлд ашиглах боломжтой бүтээгдэхүүн, эсхүл арга, ажиллагаанд хамаарах техникийн шийдлийг шинэ бүтээлд тооцож патентаар хамгаална.

5.2.Техникийн өмнөх түвшинд үл хамаарах техникийн шийдлийг “шинэ” гэж үзэх бөгөөд дараахь нөхцөлийг техникийн өмнөх түвшинд хамааруулна:

5.2.1.шинэ бүтээлийн мэдүүлгийн анхдагч огноо, эсхүл давамгайлах огнооноос өмнө бичгээр, амаар, эсхүл бусад хэлбэрээр Монгол Улсад болон гадаадад нийтлэгдсэн, эсхүл уламжлагдан нийтэд илэрхий болсон шийдэл, эсхүл мэдлэг;

5.2.2.шинэ бүтээлийн мэдүүлгийн анхдагч огнооноос өмнө, эсхүл давамгайлах огнооноос өмнө бусад этгээдийн Монгол Улсад мэдүүлсэн, албан ёсны хэвлэлд нийтлэгдсэн, патент олгогдсон шинэ бүтээл, ашигтай загвар.

5.3.Шинэ бүтээлд хамаарах мэдээллийг зохион бүтээгч буюу мэдүүлэг гаргагч өөрөө, эсхүл шууд буюу шууд бусаар уг мэдээллийг олж авсан этгээд нийтийн хүртээл болгосон хэдий ч тэрхүү өдрөөс хойш 12 сарын дотор уг шинэ бүтээлийн патентын мэдүүлгийг оюуны өмчийн байгууллагад гаргасан бол энэ нь “шинэ” гэх шалгуурыг үгүйсгэх нөхцөл болохгүй бөгөөд үүнийг мэдүүлэг гаргагч нотлох үүрэгтэй.

5.4.Шинэ бүтээлийн шийдлийг патентын мэдүүлгийн анхдагч огноо, эсхүл давамгайлах огнооноос өмнөх техникийн түвшинтэй харьцуулахад холбодох мэргэжлийн хүний зохих мэдлэгийн хүрээнд илэрхий ялгарах давуу шинж чанартай байвал “шинэ бүтээлийн түвшин” агуулсан гэж үзнэ. Техникийн өмнөх түвшинд энэ зүйлийн 5.3-т заасан нь хамаарч байвал үүнийг “шинэ бүтээлийн түвшин” тогтооход харгалзахгүй.

5.5.Шинэ бүтээлийн шийдлийг үйлдвэрлэлийн аливаа салбарт үйлдвэрлэж буюу ашиглаж болохуйц, эсхүл үр ашиг өгөхүйц байвал “үйлдвэрлэлд ашиглах боломжтой” гэж үзнэ.

### **6 дугаар зүйл.Шинэ бүтээлд тооцохгүй шийдэл**

6.1.Дараахь шийдлийг шинэ бүтээлд тооцохгүй:

- 6.1.1.нээлт, шинжлэх ухааны онол, математикийн арга;
- 6.1.2.компьютерийн програм, алгоритм дангаараа;
- 6.1.3.аж ахуйн ба бизнесийн үйл ажиллагаа, боловсрол, сургалтын арга, зөвхөн оюуны үйлдэл хийх тоглоом тоглоход зориулсан бүдүүвч, дүрэм, аргачлал;
- 6.1.4.барилга, байгууламж, газар, талбайн төлөвлөлт, зохион байгуулалт;
- 6.1.5.бүтээгдэхүүний гаднах хийц, хэлбэрт хамаарах уран сайхны шийдэл.

6.2.Компьютерийн програм, алгоритм нь шинэ бүтээлийн бүрэлдэхүүн хэсэг бол энэ нь патентаар хамгаалагдах эсэхэд нөлөөлөхгүй.

## **7 дугаар зүйл.Шинэ бүтээлийн патент олгохгүй шийдэл**

7.1.Дараахь шинэ бүтээлийн шийдэлд патент олгохгүй:

7.1.1.нийгмийн дэг журам, зан суртахуун, байгаль орчин, хүний эрүүл мэндэд харш шийдэл;

7.1.2.бичил биетнээс бусад ургамал, амьтан, тэдгээрийн хэсэг, түүнчлэн ургамал, амьтан, тэдгээрийн хэсгийг бий болгох биологийн үндсэн арга;

7.1.3.ургамлын сорт, амьтны үүлдэр;

7.1.4.хүн, мал, амьтны биед хэрэглэх эмчилгээний арга, мэс заслын арга ба оношилгооны арга;

7.1.5.байгалийн бодис, бүтээгдэхүүн, түүнийг түүх, ялгах, салгах, цэвэршүүлэх арга;

7.1.6.хүн, амьтны клон гаргаж авах арга, эсийн генийн төрөлх байдлыг өөрчлөх арга.

7.2.Энэ зүйлийн 7.1.2-т биологийн бус болон микробиологийн үйл ажиллагаа хамаарахгүй.

7.3.Энэ зүйлийн 7.1.4-т хүн, мал, амьтны биед хэрэглэх эмчилгээний горим, мэс засал, эсхүл оношилгоонд хэрэглэгдэх бүтээгдэхүүн, оношлуур, төхөөрөмж, бодис, нийлэмж болон найрлага хамаарахгүй.

## **8 дугаар зүйл.Ашигтай загварын патентаар хамгаалагдах шийдэл, шалгуур**

8.1.Багаж, хэрэгсэл, төхөөрөмжийн бүтээц, хийц, тохиргоо, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэгт хамаарах шинэ, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шийдлийг ашигтай загварт тооцож патентаар хамгаална.

8.2.Ашигтай загварын мэдүүлгийн анхдагч огнооноос өмнө Монгол Улсад үйлдвэрлэлд ашиглагдан нийтэд илэрхий болоогүй, патентын мэдээллийн санд бүртгэгдээгүй техникийн шийдлийг “шинэ” гэж үзнэ.

8.3.Ашигтай загварыг үйлдвэрлэлд ашиглах боломжтой байх ба үүнийг энэ хуулийн 5.5-д зааснаар ойлгоно.

## **9 дүгээр зүйл.Ашигтай загварт тооцохгүй шийдэл**

9.1.Дараахь шийдлийг ашигтай загварт тооцохгүй:

- 9.1.1.арга, ажиллагаа;
- 9.1.2.бодис, найрлага, химийн нэгдэл;
- 9.1.3.энэ хуулийн 7.1.1-д заасан шийдэл.

## **10 дугаар зүйл.Ашигтай загварын патент олгохгүй шийдэл**

10.1.Энэ хуулийн 6.1.2, 6.1.4, 6.1.5-д заасан шийдэлд ашигтай загварын патент олгохгүй.

10.2.Энэ хуулийн 6.2 дахь хэсэг ашигтай загварт нэгэн адил хамаарна.

## **11 дүгээр зүйл.Патент авах эрх**

11.1.Шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээгч нь патент авах, патент авах эрхээ өв залгамжлуулах, бусдад шилжүүлэх эрхтэй.

11.2.Ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загварын патент авах эрхийг ажил олгогч эдэлнэ.

11.3.Шинэ бүтээл, ашигтай загварыг гэрээний үндсэн дээр зохион бүтээсэн бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол патент авах эрхийг захиалагч, эсхүл санхүүжүүлэгч этгээд эдэлнэ.

11.4.Шинэ бүтээл, ашигтай загварыг хамтран зохион бүтээсэн бол патент авах эрхийг хамтран эдэлнэ. Шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээхэд техникийн, зохион байгуулалтын, эсхүл санхүүгийн туслалцаа үзүүлсэн, эсхүл патентын мэдүүлэг гаргах, патент авахад дэмжлэг үзүүлсэн этгээдийг хамтран зохион бүтээгч гэж тооцохгүй.

11.5.Ижил шинэ бүтээл, ашигтай загварыг бие даан тусдаа зохион бүтээсэн бол патент авах эрхийг анхдагч, эсхүл давамгайлах огноотой патентын мэдүүлгийг түрүүлж гаргасан этгээд эдэлнэ.

## **12 дугаар зүйл.Ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загвар**

12.1.Шинэ бүтээл, ашигтай загварыг дараахь тохиолдолд ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загвар гэж үзнэ:

12.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад зохион бүтээсэн;

12.1.2.ажил олгогчийн өгсөн албан даалгаврыг биелүүлэх явцад зохион бүтээсэн;

12.1.3.ажил олгогчийн технологи, төхөөрөмж, материал, мэдээлэл, туршлага зэрэг нөөцийг ашиглаж зохион бүтээсэн.

12.2.Шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээсэн ажилтан энэ тухай ажил олгогчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

12.3.Ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг ажил олгогч оюуны өмчийн байгууллагад гаргана.

12.4.Хэрэв ажил олгогч энэ зүйлийн 12.2-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 3 сарын дотор патентын мэдүүлэг гаргаагүй бол патент авах эрхийг зохион бүтээгч ажилтан эдэлнэ.

12.5.Ажил олгогч нь ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загварын патент авсан тохиолдолд зохион бүтээгч ажилтантай гэрээ байгуулж зохих төлбөр төлнө. Ажил олгогч хөдөлмөрийн гэрээгээр шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээх үүрэг ажилтанд хүлээлгэж, зохих цалин хөлс олгож байсан бол энэхүү төлбөрийг төлөхгүй.

12.6.Ажил олгогч нь ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загварын патент авснаас хойш 6 сарын дотор, эсхүл патент авахаас өмнө шинэ бүтээл, ашигтай загварыг ашиглаж эхэлсэн бол үүнээс хойш 1 жилийн дотор зохион бүтээгч ажилтантай энэ зүйлийн 12.5-д заасан гэрээг байгуулах бөгөөд уг гэрээгээр төлбөр төлөх нөхцөл, хэмжээ, түүнийг олгох журмыг тусгана. Төлбөрийн хэмжээг тогтооход тухайн шинэ бүтээл, ашигтай загварын эдийн засгийн үнэлгээ, ашигласнаас олох үр ашиг, хоёр талын оруулсан хувь нэмэр зэргийг харгалзана.

12.7.Энэ зүйлийн 12.5-д заасан гэрээ байгуулаагүй тохиолдолд төлбөрийн хэмжээг тогтоолгохоор шүүхэд хандаж болно.

12.8.Энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд зохион бүтээсэн шинэ бүтээл, ашигтай загварын патент авах эрхийг зохион бүтээгч ажилтан эдэлнэ.

### **13 дугаар зүйл.Засгийн газрын захиалгаар, улсын төсвийн санхүүжилтээр зохион бүтээсэн шинэ бүтээл, ашигтай загвар**

13.1.Засгийн газрын захиалгаар, улсын төсвийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээсэн бол энэ тухай захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

13.2.Засгийн газрын захиалгаар, улсын төсвийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон шинэ бүтээл, ашигтай загварын патент авах эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэгч эдэлнэ.

13.3.Засгийн газрын захиалгаар, улсын төсвийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явцад бий болсон шинэ бүтээл, ашигтай загварт патент авах эрхийг захиалагч эдлэхээр гэрээнд заасан бол патент авах эрхийг эрх шилжүүлэх гэрээний үндсэн дээр захиалагчид шилжүүлнэ.

13.4.Засгийн газрын захиалгаар, улсын төсвийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон шинэ бүтээл, ашигтай загварын патент авах эрхийг захиалагч төрийг төлөөлж эдлэхээр гэрээнд заасан бол

захиалагч энэ зүйлийн 13.1-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 6 сарын дотор оюуны өмчийн байгууллагад патентын мэдүүлэг гаргаж болох бөгөөд патентын мэдүүлэг гаргаагүй тохиолдолд патент авах эрхийг гүйцэтгэгч эдэлнэ.

#### **14 дүгээр зүйл.Зохион бүтээгчийн нэрийг дурдах**

14.1.Зохион бүтээгч нэрээ дурдуулахаас татгалзсан тухай Оюуны өмчийн байгууллагад бичгээр мэдэгдсэнээс бусад тохиолдолд шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг, патент, албан ёсны тогтмол хэвлэлд зохион бүтээгчийн нэрийг дурдана.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ШИНЭ БҮТЭЭЛ, АШИГТАЙ ЗАГВАРЫН ПАТЕНТЫН МЭДҮҮЛЭГ, ТҮҮНД ШҮҮЛТ ХИЙХ**

#### **15 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг гаргах**

15.1.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг энэ хуулийн 11.1-д заасан этгээд, эсхүл түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээд оюуны өмчийн байгууллагад бичгээр гаргана.

15.2.Патентын мэдүүлэг гаргагч патентын мэдүүлэг гаргахдаа оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлж болно.

15.3.Монгол Улсад байнга оршин суудаггүй, эсхүл үйл ажиллагаа явуулдаггүй харьяалалгүй хүн, гадаад улсын иргэн, хуулийн этгээд шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн гаргана.

15.4.Шинэ бүтээл тус бүрт патентын мэдүүлэг гаргах бөгөөд нэг зориулалттай, нэгдмэл байдлаар ашиглагдах шинэ бүтээлд нэг патентын мэдүүлэг гаргаж болно.

15.5.Ашигтай загвар тус бүрт нэг патентын мэдүүлэг гаргах бөгөөд нэг зориулалттай, нэгдмэл байдлаар ашиглагдах ашигтай загварт нэг патентын мэдүүлэг гаргаж болно.

#### **16 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг**

16.1.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг дараахь зүйлээс бүрдэнэ:

16.1.1.оюуны өмчийн байгууллагаас баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;

16.1.2.шинэ бүтээл, ашигтай загварын тодорхойлолт;

16.1.3.шинэ бүтээл, ашигтай загварын томьёолол;

16.1.4.шаардлагатай тохиолдолд шинэ бүтээл, ашигтай загварын мөн чанарыг тайлбарласан зураг, бүдүүвч;

16.1.5.товч тайлбар;

16.1.6.үйлчилгээний хөлс төлсөн баримт;

16.1.7.зохион бүтээгч бус этгээд мэдүүлэг гаргах бол патент авах эрхээ нотолсон баримт.

16.1.8.оюуны өмчийн байгууллагаас баталсан маягтын дагуу гаргасан зохион бүтээгчийн баталгаа;

16.1.9.мэдүүлэг гаргагчийг оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч төлөөлж байгаа бол итгэмжлэл;

16.1.10.давамгайлах эрх хүссэн бол үүнийг нотлох баримт;

16.1.11.хүн амын хүнсний хангамж, эрүүл ахуйтай холбоотой шинэ бүтээл, ашигтай загварын тухайд хүний эрүүл мэнд, биед хохирол учруулахгүйг нотолсон эрүүл ахуй, халдвар судлалын байгууллагын магадлагаа, тодорхойлолт.

16.2.Энэ зүйлийн 16.1.1-д заасан өргөдөлд дараахь зүйлийг тусгана:

16.2.1.патент авах тухай хүсэлт;

16.2.2.шинэ бүтээл, ашигтай загварын нэр;

16.2.3.патентын олон улсын ангилал;

16.2.4.мэдүүлэг гаргагч нь хувь хүн бол түүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, байнга оршин суугаа газрын хаяг, иргэний харьяалал, гарын үсэг;

16.2.5.мэдүүлэг гаргагч нь хуулийн этгээд бол түүний оноосон нэр, өмчийн хэлбэр, албан ёсны хаяг, үүсгэн байгуулагдсан улсын нэр, үйл ажиллагаа явуулдаг улсын нэр, эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг;

16.2.6.зохион бүтээгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, иргэний харьяалал, байнга оршин суудаг улсын нэр;

16.2.7.патент эзэмшигч нь хувь хүн бол түүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, байнга оршин суугаа газрын хаяг, иргэний харьяалал, гарын үсэг;

16.2.8.патент эзэмшигч нь хуулийн этгээд бол түүний оноосон нэр, өмчийн хэлбэр, албан ёсны хаяг, үүсгэн байгуулагдсан улсын нэр, үйл ажиллагаа явуулдаг улсын нэр, эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг;

16.2.9.мэдүүлэг гаргагчийг оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч төлөөлж байгаа бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, гарын үсэг;

16.2.10.давамгайлах эрх хүсэх тохиолдолд энэ тухай мэдэгдэл;

16.2.11.хавсаргасан баримт бичгийн жагсаалт, хуудасны тоо.

16.3.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг монгол хэлээр үйлдэнэ.

16.4.Шинэ бүтээл, ашигтай загварыг мэдүүлэхдээ энэ зүйлийн 16.1.2, 16.1.3, 16.1.5-д заасныг өөр хэлээр гаргасан тохиолдолд мэдүүлэг гаргасан өдрөөс хойш 2 сарын дотор монгол хэлэнд орчуулж ирүүлнэ.

16.5.Мэдүүлэг гаргагч нь энэ зүйлийн 16.4-т заасан хугацааг нэг сараар сунгуулах тухай хүсэлт гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

16.6.Мэдүүлэг гаргагч нь энэ зүйлийн 16.1.2, 16.1.3, 16.1.5-д заасныг энэ зүйлийн 16.4, 16.5-д заасан хугацааны дотор монгол хэлэнд орчуулж ирүүлээгүй бол мэдүүлэг



гаргагчийг патентын мэдүүлгээсээ татгалзсанд тооцож мэдүүлгийг хүчингүй болгож, энэ тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

16.7.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийн дараахь туслах баримт бичгийг мэдүүлэг гаргах үед, эсхүл мэдүүлэг гаргаснаас хойш 3 сарын дотор ирүүлнэ:

- 16.7.1.зохион бүтээгчийн баталгаа;
- 16.7.2.эрх шилжүүлэх гэрээ;
- 16.7.3.итгэмжлэл.

16.8.Мэдүүлэг гаргагч нь энэ хуулийн 16.7-д заасан хугацааг гурван сар хүртэл хугацаагаар сунгуулах тухай хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

16.9.Шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлэгт тавигдах шаардлага, мэдүүлэг бүртгэх, тэдгээрт өөрчлөлт оруулахтай холбоотой журмыг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

### **17 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын тодорхойлолт**

17.1.Шинэ бүтээл, ашигтай загварын тодорхойлолт нь тухайн шийдлийн өмнөх техник, технологийн түвшингээс онцгой ялгарах шинж чанарыг болон хамаарах салбарын мэргэжилтэн бүрэн ойлгож, хэрэгжүүлж болохуйц байдлаар тодорхой тайлбарлан бичсэн цогц мэдээлэл байна. Шинэ бүтээл, ашигтай загварын тодорхойлолтод дараахь зүйлийг тусгана:

- 17.1.1.шинэ бүтээл, ашигтай загварын нэр;
- 17.1.2.шийдлийн хамаарах болон ашиглах салбар;
- 17.1.3.дэвшүүлж байгаа шийдэлтэй төсөөтэй шийдлүүдийн мөн чанар;
- 17.1.4.төсөөтэй шийдлүүдийн дутагдал;
- 17.1.5.дэвшүүлж байгаа шийдлийн зорилго;
- 17.1.6.дэвшүүлж байгаа шийдлийн мөн чанар;
- 17.1.7.шийдлийг бодитоор хэрэгжүүлэх арга;
- 17.1.8.шаардлагатай тохиолдолд шийдлийн мөн чанарыг тайлбарлах зураг.

17.2.Шинэ бүтээл, ашигтай загварын нэр нь товч, тодорхой, шинэ бүтээлийн ангилалд заасан нэрийг баримталсан байна. Тодорхойлолтод бичсэн шинэ бүтээл, ашигтай загварын нэр нь энэ хуулийн 16.1.1-д заасан өргөдөлд дурдсан нэртэй адил байх бөгөөд хийсвэр, эсхүл бэлгэдлийн шинжтэй байж болохгүй.

17.3.Шинэ бүтээлийг бий болгоход Монгол Улсын биологийн, эсхүл генетикийн нөөц, түүнчлэн түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг шууд буюу шууд бусаар ашигласан, эсхүл шинэ бүтээлийг ашиглахад хэрэглэх бол эдгээрийн гарал үүслийг шинэ бүтээлийн тодорхойлолтод онцлон зааж өгнө.

17.4.Шинэ бүтээлийг бий болгоход ашигласан, эсхүл шинэ бүтээлийг ашиглахад хэрэглэгдэх Монгол Улсын биологийн, эсхүл генетикийн нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг тодорхойлолтод заагаагүй, эсхүл худал мэдээлэл өгсөн нь патент олгохоос татгалзах, эсхүл олгосон патентыг хүчингүй болгох үндэслэл болно.

## **18 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын томьёолол**

18.1.Шинэ бүтээл, ашигтай загвар нь нэг, эсхүл түүнээс дээш үндсэн томьёололтой, үндсэн томьёоллоос хамаарах нэг, эсхүл түүнээс дээш туслах томьёололтой байж болно.

18.2. Шинэ бүтээл, ашигтай загварын томьёолол нь дараахь шаардлагыг хангасан байна:

18.1.1.томьёолол нь тухайн шинэ бүтээл, ашигтай загварын онцгой ялгарах шинж чанар, эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлсон, ойлгомжтой, товч, тодорхой байх;

18.1.2.томьёололд дурдагдсан шинж чанар нь тодорхойлолтод бүрэн тусгагдсан байх.

## **19 дүгээр зүйл.Товч тайлбар**

19.1.Товч тайлбар нь шинэ бүтээл, ашигтай загварын талаар техникийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд түүнийг эрхийн хамгаалалтын хүрээг тогтооход ашиглахгүй.

19.2.Ашигтай загварын товч тайлбарт ашигтай загварын үндсэн шинжийг илэрхийлсэн нэг зураг хавсаргана.

19.3.Шинэ бүтээлийн товч тайлбарт шаардлагатай тохиолдолд түүний үндсэн шинжийг илэрхийлсэн нэг зураг хавсаргана.

## **20 дугаар зүйл.Зураг, бүдүүвч**

20.1.Шинэ бүтээлийн мөн чанарыг бүрэн тайлбарлахад зайлшгүй шаардлагатай тохиолдолд шинэ бүтээлийн объектийн зураг, эсхүл технологийн бүдүүвчийг хавсаргана.

20.2.Ашигтай загварын мөн чанарыг бүрэн тайлбарлахад хүрэлцэхүйц тооны зургийг хавсаргана.

## **21 дүгээр зүйл.Давамгайлах эрх, давамгайлах эрхийг хүлээн зөвшөөрөх**

21.1.Мэдүүлэг гаргагч нь патентын мэдүүлэгтээ Парисын конвенцын, эсхүл Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн оронд гаргасан давамгайлах огнооны эрх үүсэх үндэслэл болсон нэг, эсхүл түүнээс дээш мэдүүлэгт үндэслэн Парисын конвенцын 4 дүгээр зүйлийн дагуу давамгайлах эрх хүсэж болно.

21.2.Мэдүүлэг гаргагч нь мэдүүлгийн анхдагч огнооноос, эсхүл олон улсын мэдүүлгийг Монгол Улсад хүлээн авснаас хойш 2 сарын дотор давамгайлах эрх хүсэх бол үйлчилгээний хөлс төлнө.

21.3.Энэ зүйлийн 21.1-д заасан давамгайлах эрх олгогдох хугацаа нь 12 сар байх бөгөөд уг хугацааг Парисын конвенцын 4 дүгээр зүйлийн дагуу тооцно.

21.4.Энэ зүйлийн 21.1-д заасан давамгайлах эрх үүсэх үндэслэл болсон патентын мэдүүлэг нь энэ зүйлийн 21.1-д заасан аль нэг оронд гаргасан, эсхүл Патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу гаргасан олон улсын мэдүүлэг байна. Давамгайлах эрх үүсэх

үндэслэл болсон мэдүүлэг нь шинэ бүтээлийн, эсхүл ашигтай загварын патентын мэдүүлэг байна.

21.5.Мэдүүлэг гаргагч нь патентын мэдүүлэгтээ давамгайлах огнооны эрх хүссэн бол нотлох баримтыг хавсаргана. Нотлох баримт нь давамгайлах эрх үүсэх үндэслэл болсон мэдүүлгийг хүлээн авсан байгууллагаас олгосон гэрчлэх баримт байна.

21.6.Мэдүүлэг гаргагч нь Парисын конвенцын, эсхүл Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн орны нутаг дэвсгэр дээр зохион байгуулагдсан албан ёсны болон албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын үзэсгэлэнд шинэ бүтээл, ашигтай загварыг нийтэд дэлгэсэн бол ийнхүү нийтэд дэлгэсэн өдрөөс хойш 12 сарын дотор үзэсгэлэнгийн давамгайлах эрх хүсэж болно.

21.7.Давамгайлах огноог нотлох баримтыг мэдүүлэгт хавсаргах ба хавсаргаагүй бол мэдүүлэг гаргасан өдрөөс хойш 2 сарын дотор ирүүлж болох бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаантай бол мэдүүлэг гаргагч энэ хугацааг гурав хүртэл сараар сунгуулах тухай хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

21.8.Энэ зүйлийн 21.6, 21.7-д заасан хугацаанд давамгайлах огноог нотлох баримтыг ирүүлээгүй бол давамгайлах эрх хүсээгүйд тооцно.

## **22 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийн анхдагч огноог тогтоох, мэдүүлгийн бүрдлийн шүүлт хийх**

22.1.Оюуны өмчийн байгууллага нь шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор патентын мэдүүлэг хүлээн авсан тухай мэдүүлэг гаргагчид, эсхүл оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч (цаашид “мэдүүлэг гаргагч” гэх)-д бичгээр мэдэгдэнэ.

22.2.Оюуны өмчийн байгууллага нь шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг хүлээн авснаас хойш ажлын 20 өдрийн дотор тухайн мэдүүлэг нь энэ хуулийн 15, 16, 21 дүгээр зүйлд заасан шаардлага хангасан эсэхийг шалгана.

22.3.Оюуны өмчийн байгууллага нь шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийн бүрдэл хангагдсан гэж үзвэл патентын мэдүүлэг хүлээн авсан өдрөөр анхдагч огноо тогтоож, мэдүүлгийн улсын бүртгэлд бүртгэсэн тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

22.4.Шинэ бүтээл, ашигтай загварын олон улсын мэдүүлгийн хувьд анхдагч огноо нь Патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын Олон Улсын Товчоонд, эсхүл хүлээн авагч байгууллагад патентын мэдүүлэг хүлээн авсан огноо байна.

22.5.Оюуны өмчийн байгууллага нь шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийн бүрдэл хангагдаагүй гэж үзвэл нэмэлт, өөрчлөлт хийх тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэх бөгөөд мэдүүлэг гаргагч нь уг мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 2 сарын дотор зохих нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлнэ. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

22.6.Мэдүүлэг гаргагч нь энэ зүйлийн 22.5-д заасан хугацааг гурван сар хүртэл хугацаагаар сунгуулах хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

22.7.Мэдүүлэг гаргагч нь энэ зүйлийн 22.5, 22.6-д заасан хугацаанд нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлээгүй бол мэдүүлэг гаргагчийг мэдүүлгээсээ татгалзсанд тооцож, патентын мэдүүлгийг хүчингүй болгосон тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

22.8.Мэдүүлэг гаргагч нь энэ зүйлийн 22.6, 22.7-д заасан хугацаанд нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлсэн боловч энэ нь мэдүүлгийн бүрдлийн шаардлага хангаагүй бол мэдүүлэг гаргагчид бүрдэл хангуулах тухай шаардлагыг бичгээр мэдэгдэх бөгөөд мэдүүлэг гаргагч нь уг шаардлагыг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор зохих нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлнэ. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

22.9.Оюуны өмчийн байгууллага нь ашигтай загварын мэдүүлгийн бүрдлийн шүүлтийг анхдагч огнооноос хойш 2 сар, шинэ бүтээлийн мэдүүлгийн бүрдлийн шүүлтийг анхдагч огнооноос, эсхүл олон улсын мэдүүлгийг Монгол Улсад хүлээн авсан өдрөөс хойш 12 сарын дотор хийж, энэ хуулийн 17, 18, 20 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, техникийн өмнөх түвшинг илрүүлэх боломжтой эсэхийг тогтооно.

22.10.Мэдүүлэг гаргагч нь энэ зүйлийн 22.9-д заасан хугацааг зургаан сар хүртэл хугацаагаар сунгуулах тухай хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

22.11.Оюуны өмчийн байгууллага нь бүрдлийн шүүлтийн дүгнэлтэд үндэслэн дараахь тохиолдолд патентын мэдүүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ:

22.11.1.шинэ бүтээлийн нэгдмэл байдлын шаардлага хангаагүй;

22.11.2.шинэ бүтээл, ашигтай загварын тодорхойлолт, томъёолол, зураг бүдүүвч нь энэ хуулийн 17,18, 20 дугаар зүйлд заасан шаардлага хангаагүй.

22.12.Мэдүүлэг гаргагч нь энэ зүйлийн 22.11-д заасан мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 2 сарын дотор нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлээгүй бол мэдүүлэг гаргагчийг патентын мэдүүлгээсээ татгалзсанд тооцсон тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

22.13.Мэдүүлэг гаргагч нь энэ зүйлийн 22.12-т заасан хугацааг зургаан сар хүртэл хугацаагаар сунгуулах тухай хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

22.14.Энэ зүйлийн 22.13-т заасан хугацаанд, эсхүл сунгагдсан хугацааны дотор ирүүлсэн нэмэлт, өөрчлөлт нь энэ хуулийн 17, 18, 20 дугаар зүйлд заасан шаардлага хангаагүй бол Оюуны өмчийн байгууллага нь патентлагдах түвшин тогтоох шаардлага хангуулахаар мэдүүлэг гаргагчид мэдэгдэх ба мэдүүлэг гаргагч нь 20 хоногийн дотор зохих нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлнэ. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

22.15.Энэ зүйлийн 22.14-т заасан хугацаанд нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлээгүй бол мэдүүлэг гаргагчийг патентын мэдүүлгээсээ татгалзсанд тооцсон тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

**23 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг салгах, нэгтгэх, шилжүүлэх, өөрчлөлт оруулах, цуцлах**

23.1.Мэдүүлэг гаргагч нь мэдүүлгийн бүрдлийн шүүлтээс мөн чанарын шүүлтийн явцад хэдийд ч мэдүүлгээ хоёр, түүнээс дээш мэдүүлэгт салгах тухай хүсэлт гаргаж болно. Салгасан мэдүүлэг нь анх ирүүлсэн тодорхойлолтын агуулгын хүрээнээс халихгүй.

23.2.Салгасан мэдүүлэг тус бүрт үндсэн мэдүүлгийн анхдагч болон давамгайлах огноо авах эрхтэй. Салгасан мэдүүлэг тус бүрт үйлчилгээний хөлс төлнө.

23.3.Мэдүүлэг гаргагч нь хамтаар ашиглагдах шинэ бүтээл, ашигтай загварын хэд хэдэн мэдүүлгийг нэгтгэх тухай хүсэлт гаргаж болно.

23.4.Мэдүүлэг гаргагч нь мэдүүлгийн бүрдлийн шүүлтээс мөн чанарын шүүлтийн явцад хэдийд ч анх ирүүлсэн тодорхойлолтын агуулгын хүрээнээс халихгүйгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

23.5.Мэдүүлэг гаргагч нь мэдүүлгийн бүрдлийн шүүлтээс мөн чанарын шүүлтийн явцад хэдийд ч энэ хуулийн 8-10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан шинэ бүтээлийн мэдүүлгийг ашигтай загварын мэдүүлэгт шилжүүлж болно.

23.6.Мэдүүлэг гаргагч нь мэдүүлгийн бүрдлийн шүүлтээс мөн чанарын шүүлтийн явцад хэдийд ч энэ хуулийн 5-7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан ашигтай загварын мэдүүлгийг шинэ бүтээлийн мэдүүлэгт шилжүүлж болно.

23.7.Мэдүүлэг гаргагч нь мэдүүлгийн бүрдлийн шүүлтээс мөн чанарын шүүлтийн явцад хэдийд ч мэдүүлгээ хүчингүй болгуулах тухай хүсэлт гаргаж болно.

#### **24 дүгээр зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлэгт хайлт хийх, нийтэд мэдээлэх**

24.1.Оюуны өмчийн байгууллага нь энэ хуулийн 17, 18 дугаар зүйлд заасан шаардлагыг бүрэн хангасан патентын мэдүүлэгт шинэ бүтээл, ашигтай загварын техникийн өмнөх түвшинг илрүүлэх зорилгоор хайлт хийж, тайлан гаргана.

24.2.Ашигтай загварын хайлтын тайланг анхдагч огнооноос хойш 2 сар, шинэ бүтээлийн хайлтын тайланг анхдагч огнооноос, эсхүл олон улсын мэдүүлгийг Монгол Улсад хүлээн авснаас өдрөөс хойш 12 сарын дотор гаргаж, мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

24.3.Мэдүүлэг гаргагч нь хайлтын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 3 сарын дотор шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэгтээ тодорхойлолтын хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

24.4.Мэдүүлэг гаргагч нь энэ зүйлийн 24.3-т заасан хугацааг зургаан сар хүртэл хугацаагаар сунгуулах тухай хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

24.5.Хайлтын тайлан нь шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг хүчингүй болгох, эсхүл патент олгохоос татгалзах үндэслэл болохгүй.

24.6.Шинэ бүтээлийн хайлтын тайланг 30 хоногийн дотор ном зүй, тодорхойлолт, томъёолол, товч тайлбар, зургийн хамт албан ёсны тогтмол хэвлэлд нийтэлнэ.

24.7. Энэ зүйлийн 24.6-д заасныг нийтлэхээс өмнө патентын мэдүүлгийн талаар гуравдагч этгээдэд мэдээлэл өгөхгүй ба патентын мэдүүлгийн агуулгыг нууцална.

24.8.Шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлэгт хайлт, мөн чанарын шүүлт хийх журмыг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

### **25 дугаар зүйл.Шинэ бүтээлийн патентын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийх, нийтэд мэдээлэх**

25.1.Шинэ бүтээлийн патентын мэдүүлгийн мөн чанарын шүүлтийг оюуны өмчийн байгууллага анхдагч огнооноос хойш, эсхүл олон улсын мэдүүлгийг Монгол Улсад хүлээн авсан өдрөөс хойш 24 сарын дотор мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр гүйцэтгэнэ. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

25.2.Энэ хуулийн 25.1-д заасан хүсэлтийг мэдүүлэг гаргагч анхдагч огнооноос, эсхүл олон улсын мэдүүлгийг Монгол Улсад хүлээн авсан өдрөөс хойш 15 сарын дотор гаргана.

25.3.Дэвшүүлж байгаа шийдэл нь энэ хуулийн 5-7 дугаар зүйлд заасан патентлагдах чадварын шалгуур хангасан эсэх тухай мөн чанарын шүүлтийн дүгнэлт гаргаж, тайлангийн хамт мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

25.4.Дэвшүүлж байгаа шинэ бүтээлийн шийдэл нь энэ хуулийн 5-7 дугаар зүйлд заасан патентлагдах чадварын шалгуур хангасан бол шинэ бүтээлийн ном зүй, товч тайлбар, тодорхойлолт, томъёоллыг албан ёсны тогтмол хэвлэлд 30 хоногийн дотор нийтэлнэ.

25.5.Мөн чанарын шүүлтийн явцад мэдүүлэгт тодорхой хугацааны дотор нэмэлт, өөрчлөлт оруулах тухай мэдэгдлийг шинжээч мэдүүлэг гаргагчид хүргүүлж болно.

25.6.Мэдүүлэг гаргагч нь мөн чанарын шүүлтийн дүгнэлтийг эс зөвшөөрвөл энэ зүйлийн 25.3-т заасан тайланг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шинжээчийн дүгнэлтэд няцаалт гаргаж болно.

25.7.Оюуны өмчийн байгууллага нь энэ зүйлийн 25.6-д заасан няцаалтыг хүлээн авсан өдрөөс хойш 1 сарын дотор анхны шинжээчийг оролцуулахгүйгээр 3 шинжээчийн бүрэлдэхүүнтэйгээр мөн чанарын шүүлт дахин хийж, тухайн шинэ бүтээлд патент олгох эсэх талаар шийдвэр бичгээр гаргаж, мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

25.8.Мэдүүлэг гаргагч нь энэ зүйлийн 25.7-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэр хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Маргаан шийдвэрлэх зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

### **26 дугаар зүйл.Ашигтай загварын патентын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийх, нийтэд мэдээлэх**

26.1.Оюуны өмчийн байгууллага нь анхдагч огнооноос хойш, эсхүл олон улсын мэдүүлгийг Монгол Улсад хүлээн авсан өдрөөс хойш 3 сарын дотор ашигтай загварын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийнэ.

26.2.Ашигтай загварын мэдүүлэг нь энэ хуулийн 8-10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх тухай мөн чанарын шүүлтийн дүгнэлт гаргаж, тайлангийн хамт мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

26.3.Ашигтай загварын мэдүүлэг нь энэ хуулийн 8-10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан бол албан ёсны хэвлэлд нийтэлнэ.

26.4. Мэдүүлэг гаргагч нь мөн чанарын шүүлтийн дүгнэлтийг эс зөвшөөрвөл хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Маргаан шийдвэрлэх зөвлөлд гомдол гаргаж болно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ПАТЕНТЫН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ**

### **27 дүгээр зүйл.Бүтээгдэхүүний загварын хамгаалалт**

27.1.Бүтээгдэхүүний загварыг Оюуны өмчийн байгууллага нь энэ хуульд заасны дагуу олгосон патентаар хамгаална.

### **28 дугаар зүйл.Бүтээгдэхүүний загварын патентаар хамгаалагдах шийдэл, патент олгох шалгуур**

28.1.Бүтээгдэхүүний загварын шийдэл нь “шинэ” болон “өвөрмөц шинж”-ийг агуулсан бол патентаар хамгаалагдана.

28.2.Бүтээгдэхүүний загварын шийдэл нь патентын мэдүүлгийн анхдагч огноо, эсхүл давамгайлах огнооноос өмнө нийтэд илэрхий болоогүй бол “шинэ” гэж үзнэ.

28.3.Бүтээгдэхүүний загварын шийдлийн шинж чанар нь тухайн бүтээгдэхүүний гадаад гоо зүйн шинжийн болон зохицох онцлог шинж чанар болон оюуны бүтээлч шинжийг агуулж байвал түүнийг “өвөрмөц шинжтэй” гэж үзнэ.

28.4.Бүтээгдэхүүний загварыг, эсхүл түүнд хамаарах мэдээллийг зохион бүтээгч, эсхүл мэдүүлэг гаргагч өөрөө, эсхүл шууд буюу шууд бусаар уг мэдээллийг олж авсан этгээд нийтийн хүртээл болгосон хэдий ч тэрхүү өдрөөс хойш 6 сарын дотор уг бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийг Оюуны өмчийн байгууллагад гаргасан бол энэ нь “шинэ” гэх шалгуурыг үгүйсгэх нөхцөл болохгүй бөгөөд мэдүүлэг гаргагч үүнийг нотлох үүрэгтэй.

### **29 дүгээр зүйл.Бүтээгдэхүүний загварт тооцохгүй шийдэл**

29.1.Дараахь шийдлийг бүтээгдэхүүний загварт тооцохгүй:

29.1.1.төрийн сүлд, туг, далбаа, тамга, шагнал, одон тэмдэг болон гадаад орны төрийн далбаа, бэлгэ тэмдэг, олон улсын байгууллагын тэмдэг, бэлгэдэлтэй ижил, төсөөтэй загвар;

29.1.2.нийгмийн ашиг сонирхол, зан суртахуунд харш.

### **30 дугаар зүйл.Бүтээгдэхүүний загварын патент олгохгүй шийдэл**

30.1.Бүтээгдэхүүний загварт хамаарах шийдэл нь бүтээгдэхүүний техникийн болон үндсэн зориулалтад хамаарах бол патент олгохгүй.

### **31 дүгээр зүйл. Патентын эрх үүсэх, патент авах эрх, зохион бүтээгчийн нэрийг дурдах**

31.1.Бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчийн онцгой эрх нь бүтээгдэхүүний загварыг Оюуны өмчийн байгууллагад бүртгүүлснээр үүснэ.

31.2.Патент авах эрхийг бүтээгдэхүүний загвар зохион бүтээгч эдлэх бөгөөд патент авах эрхээ өв залгамжлуулж, эсхүл бусдад шилжүүлж болно.

31.3.Бүтээгдэхүүний загварыг ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр зохион бүтээсэн бол патент авах эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол захиалагч, эсхүл санхүүжүүлэгч этгээд эдэлнэ.

31.4.Хоёр ба түүнээс дээш этгээд бүтээгдэхүүний загварыг хамтран зохион бүтээсэн бол патент авах эрхийг хамтран эдэлнэ.

31.5.Ижил бүтээгдэхүүний загварыг бие даан тусдаа зохион бүтээсэн бол патент авах эрхийг анхдагч, эсхүл давамгайлах огноотой патентын мэдүүлгийг түрүүлж гаргасан этгээд эдэлнэ.

31.6.Зохион бүтээгч нэрээ дурдуулахаас татгалзсан тухай Оюуны өмчийн байгууллагад бичгээр мэдэгдсэнээс бусад тохиолдолд бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг, патент, патентын албан ёсны тогтмол хэвлэлд зохион бүтээгчийн нэрийг заавал дурдана.

### **32 дугаар зүйл. Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг гаргах**

32.1.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийг энэ хуулийн 31.2-т заасан этгээд Оюуны өмчийн байгууллагад бичгээр гаргана.

32.2.Бүтээгдэхүүний загварын мэдүүлгийг оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн гаргаж болно.

32.3.Монгол Улсад байнга оршин суудаггүй, эсхүл үйл ажиллагаа явуулдаггүй гадаад улсын иргэн, эсхүл хуулийн этгээд бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийг оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн гаргана.

### **33 дугаар зүйл. Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг**

33.1.Бүтээгдэхүүний загварын мэдүүлэг дараахь зүйлээс бүрдэнэ:

33.1.1.Оюуны өмчийн байгууллагаас баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;

33.1.2.бүтээгдэхүүний загварын зураг;

33.1.3.бүтээгдэхүүний загварын тодорхойлолт;

33.1.4.Оюуны өмчийн байгууллагаас баталсан маягтын дагуу гаргасан зохион бүтээгчийн баталгаа;



33.1.5. Зохион бүтээгч бус этгээд мэдүүлэг гаргах бол патент авах эрхээ нотолсон баримт;

33.1.6.мэдүүлэг гаргагч нь оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлсэн бол итгэмжлэл;

33.1.7.давамгайлах эрх хүссэн бол үүнийг нотлох баримт;

33.1.8.үйлчилгээний хөлс төлсөн баримт.

33.1.9.хавсаргасан баримт бичгийн жагсаалт.

33.2.Энэ зүйлийн 33.1.1-д заасан өргөдөлд дараахь зүйлийг тусгана:

33.2.1.бүтээгдэхүүний загварт патент олгуулах тухай хүсэлт;

33.2.2.бүтээгдэхүүний загварыг илэрхийлэх ерөнхий нэр;

33.2.3.бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал;

33.2.4.мэдүүлэг гаргагч нь хувь хүн бол түүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, харьяалал, байнга оршин суудаг улсын нэр, гарын үсэг;

33.2.5.мэдүүлэг гаргагч нь хуулийн этгээд бол түүний оноосон нэр, хэлбэр, албан ёсны хаяг, үүсгэн байгуулагдсан улсын нэр, үйл ажиллагаа явуулдаг улсын нэр, эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг;

33.2.6.зохион бүтээгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, харьяалал, байнга оршин суудаг улсын нэр;

33.2.7.мэдүүлэг гаргагчийг оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч төлөөлж байгаа бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, гарын үсэг;

33.2.8.давамгайлах эрх хүсэх тохиолдолд энэ тухай мэдэгдэл.

33.3.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийг монгол хэлээр үйлдэнэ.

33.4.Бүтээгдэхүүний загварын нэр нь бүтээгдэхүүний загварын олон улсын ангилалд заасан нэрийг баримталсан товч, тодорхой байна. Бүтээгдэхүүний загварын нэр нь хийсвэр, эсхүл бэлгэдлийн шинжтэй байж болохгүй.

33.5.Бүтээгдэхүүний загварын тодорхойлолтод бичигдсэн нэр нь энэ зүйлийн 33.2.2-т заасан өргөдөлд дурдсан нэртэй адил байна. Бүтээгдэхүүний загварын тодорхойлолтод тухайн бүтээгдэхүүний шинэ болон өвөрмөц шинжийг товч тодорхойлон бичнэ.

33.6.Бүтээгдэхүүний загварын зураг нь тухайн бүтээгдэхүүний загварыг бүрэн илэрхийлэх зураг, гэрэл зураг, эсхүл бусад график дүрслэл байна.

33.7.Бүтээгдэхүүний загварын ижил ангилалд хамаарах 50 хүртэлх бүтээгдэхүүний загварыг нэг мэдүүлгээр мэдүүлж болно.

33.8.Бүтээгдэхүүний загварын мэдүүлэг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх, тэдгээрт өөрчлөлт оруулахтай холбоотой журмыг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

### **34 дүгээр зүйл. Бүтээгдэхүүний загварын давамгайлах огноо**

34.1. Мэдүүлэг гаргагч нь мэдүүлэгтээ Парисын конвенцын, эсхүл Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн оронд гаргасан давамгайлах огнооны эрх үүсэх үндэслэл болсон өмнөх нэг, эсхүл түүнээс дээш мэдүүлэгт үндэслэн Парисын конвенцын 4 дүгээр зүйлийн дагуу давамгайлах эрх хүсэж болно.

34.2. Энэ хуулийн 34.1-д заасан давамгайлах эрх олгогдох хугацаа нь 6 сар байх бөгөөд уг хугацааг Парисын конвенцын 4 дүгээр зүйлийн дагуу тооцно.

34.3. Хэрэв мэдүүлэг гаргагч нь Парисын конвенцын, эсхүл Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн орны нутаг дэвсгэр дээр зохион байгуулагдсан албан ёсны болон албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын үзэсгэлэнд бүтээгдэхүүний загварыг нийтэд дэлгэсэн бол ийнхүү нийтэд дэлгэсэн өдрөөс хойш 6 сарын дотор үзэсгэлэнгийн давамгайлах эрх хүсэж болно.

34.3. Мэдүүлэг гаргагч энэ зүйлийн 34.2, 34.3-т заасан эрхийг хүссэн бол энэ тухай нотлох баримтыг мэдүүлэгтээ хавсаргана.

34.4. Энэ зүйлд энэ хуулийн 21.7, 21.8 нэгэн адил хамаарна.

### **35 дугаар зүйл. Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийн бүрдлийн шүүлт хийх, анхдагч огноо тогтоох**

35.1. Оюуны өмчийн байгууллага бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор патентын мэдүүлэг хүлээн авсан тухай мэдүүлэг гаргагчид, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийн бүрдлийн шүүлтийг мэдүүлэг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хийж, анхдагч огноог тогтооно.

35.3. Оюуны өмчийн байгууллага нь бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийн бүрдэл хангагдсан гэж үзвэл хүлээн авсан өдрөөр анхдагч огноог тогтоож, мэдүүлгийн улсын бүртгэлд бүртгэж, мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

35.4. Оюуны өмчийн байгууллага нь бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийн бүрдэл хангагдаагүй гэж үзвэл 1 сарын дотор зохих нэмэлт, өөрчлөлт хийх тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

35.5. Энэ хуулийн 33.1.4, 33.1.5, 33.1.6, 34.3-т заасныг мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 2 сарын дотор Оюуны өмчийн байгууллагад ирүүлнэ.

35.6. Энэ хуулийн 33.1.4, 33.1.5, 33.1.6-д заасныг 35.5-д заасан хугацаанд Оюуны өмчийн байгууллагад ирүүлээгүй бол патентын мэдүүлгээсээ татгалзсанд тооцож, патентын мэдүүлгийг хүчингүй болгоно.

35.7. Энэ хуулийн 34.3-т заасныг энэ зүйлийн 35.5-д заасан хугацаанд Оюуны өмчийн байгууллагад ирүүлээгүй бол давамгайлах эрх хүсээгүйд тооцно.

### **36 дугаар зүйл. Бүтээгдэхүүний загварын мэдүүлгийг салгах, нэгтгэх, өөрчлөлт оруулах, цуцлах**

36.1.Мэдүүлэг гаргагч нь мэдүүлгийн анхдагч огнооноос хойш мөн чанарын шүүлтийн явцад мэдүүлгээ хоёр, түүнээс дээш мэдүүлэгт салгах тухай хүсэлт гаргаж болно.

36.2.Салгасан мэдүүлэг тус бүр нь үндсэн мэдүүлгийн анхдагч болон давамгайлах огноо авах эрхтэй. Салгасан мэдүүлэг тус бүрд үйлчилгээний хөлс төлнө.

36.3. Мэдүүлэг гаргагч нь хамтаар ашиглагдах, эсхүл бүтээгдэхүүний загварын нэг ангилалд хамаарах бүтээгдэхүүний загварын хэд хэдэн мэдүүлгийг нэгтгэх тухай хүсэлт гаргаж болно.

36.4.Мэдүүлэг гаргагч нь мөн чанарын шүүлтийн явцад мэдүүлэгтээ өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

36.5.Мэдүүлэг гаргагч нь мэдүүлгээ хүчингүй болгуулах тухай хүсэлтийг мөн чанарын шүүлтийн явцад хэдийд ч гаргаж болно.

### **37 дугаар зүйл.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийн мөн чанарын шүүлт, нийтэд мэдээлэх**

37.1.Оюуны өмчийн байгууллага бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийг энэ хуулийн 27-29 дүгээр зүйлд нийцсэн эсэхэд мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 9 сарын дотор, эсхүл олон улсын мэдүүлгийг Олон улсын товчоо хэвлэснээс хойш 6 сарын дотор патентын мэдүүлгийн мөн чанарын шүүлт /цаашид “мөн чанарын шүүлт” гэх/ хийж, дүгнэлт гаргана.

37.2.Мөн чанарын шүүлтээр бүтээгдэхүүний загвар нь энэ хуулийн 27-29 дүгээр зүйлд нийцсэн гэж үзвэл Оюуны өмчийн байгууллага энэ тухай дүгнэлт гаргаж, мөн чанарын шүүлтийн тайлангийн хамт мэдүүлэг гаргагчид хүргүүлж, бүтээгдэхүүний загварын ном зүй, зургийг албан ёсны тогтмол хэвлэлд 30 хоногийн дотор нийтэлнэ.

37.3.Бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийх журмыг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

37.4.Мэдүүлэг гаргагч нь мөн чанарын шүүлтийн дүгнэлтийг эс зөвшөөрвөл хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Маргаан шийдвэрлэх зөвлөлд гомдол гаргаж болно.

### **38 дугаар зүйл.Ажлын байранд, Засгийн газрын захиалга, улсын төсвийн санхүүжилтээр зохион бүтээсэн бүтээгдэхүүний загвар**

38.1.Ажлын байранд зохион бүтээсэн, эсхүл Засгийн газрын захиалга, улсын төсвийн санхүүжилтээр зохион бүтээсэн бүтээгдэхүүний загварт энэ хуулийн 12, 13 дугаар зүйл хамаарна.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ПАТЕНТ ОЛГОХ, ПАТЕНТЫН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА, ПАТЕНТЫН ХУРААМЖ**

### **39 дүгээр зүйл.Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент олгох**

39.1.Энэ хуулийн 25.4, 37.2-т заасны дагуу нийтэд мэдээлснээс хойш 3 сарын дотор Маргаан шийдвэрлэх зөвлөлд гуравдагч этгээдээс эсэргүүцэл гаргаагүй бол Оюуны өмчийн байгууллага шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент олгоно.

39.2.Ашигтай загварын мэдүүлэг нь энэ хуулийн 8-10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан тухай мөн чанарын шүүлтийн дүгнэлтэд үндэслэн ашигтай загварын патент олгоно.

39.3.Патентын шаардлага хангасан шийдэлд нэг патент олгоно.

39.4.Оюуны өмчийн байгууллага шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварт патентын цахим гэрчилгээ олгож болно.

39.5.Патентын гэрчилгээний загварыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

#### **40 дүгээр зүйл.Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патентын хүчинтэй хугацаа**

40.1.Патент нь дараахь хугацаанд хүчинтэй байна:

- 40.1.1.шинэ бүтээлийн патент нь анхдагч огнооноос хойш 20 жил;
- 40.1.2.ашигтай загварын патент нь анхдагч огнооноос хойш 10 жил;
- 40.1.3.бүтээгдэхүүний загварын патент нь анхдагч огнооноос хойш 15 жил.

#### **41 дүгээр зүйл.Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патентын хураамж**

41.1.Патентыг хүчинтэй байлгах хугацааны хураамжийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан шатлалын дагуу төлнө.

41.2.Патентыг хүчинтэй байлгах хугацааны дараагийн жилүүдийн хураамжийг тухайн патентын хүчинтэй хугацаа дуусахаас өмнө төлнө.

41.3.Энэ зүйлийн 41.2-т заасан хугацаанд патентыг хүчинтэй байлгах хугацааны хураамжийг төлөөгүй бол Оюуны өмчийн байгууллага нь патентыг хүчинтэй байлгах хугацааны хураамж төлөх хугацааг 6 сараар сунгаж болно. Энэ тохиолдолд зохих үйлчилгээний хураамж төлнө.

41.4.Энэ зүйлийн 41.2, 41.3-т заасан хугацаанд патентыг хүчинтэй байлгах хугацааны хураамжийг төлөөгүй бол патентын эрхийг хүчингүй болгож, албан ёсны тогтмол хэвлэлд нийтэлнэ.

### **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ПАТЕНТЫН ОЛОН УЛСЫН МЭДҮҮЛЭГ**

#### **42 дугаар зүйл.Патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу Монгол Улсыг нэр заан мэдүүлсэн олон улсын мэдүүлэг**

42.1.Монгол Улсыг нэр заасан шинэ бүтээл, ашигтай загварын патентын олон улсын мэдүүлгийг энэ хуулийн дагуу гаргасан патентын мэдүүлэгтэй нэгэн адил үзэж анхдагч

огноог Патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу тогтоосон олон улсын анхдагч огноогоор тогтооно.

#### **43 дугаар зүйл.Гаагийн хэлэлцээрийн дагуу мэдүүлсэн бүтээгдэхүүний загварын олон улсын мэдүүлэг**

43.1.Монгол Улсыг нэр заасан бүтээгдэхүүний загварын олон улсын мэдүүлгийг энэ хуулийн дагуу гаргасан бүтээгдэхүүний загварын мэдүүлэгтэй нэгэн адил үзэж анхдагч огноог Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын Олон Улсын Товчоонд мэдүүлсэн огноогоор тогтооно.

43.2.Монгол Улсыг нэр заасан бүтээгдэхүүний загварын олон улсын мэдүүлэг нь энэ хуулийн 26-28 дугаар зүйлд нийцсэн эсэхэд мөн чанарын шүүлт хийнэ.

43.3.Энэ хуулийн 27-29 дүгээр зүйлд нийцээгүй гэж үзвэл Оюуны өмчийн байгууллага тухайн бүтээгдэхүүний загварыг бүртгэхээс татгалзсан тухай мэдэгдэл гаргаж, Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын Олон Улсын Товчоонд хүргүүлнэ.

#### **44 дүгээр зүйл.Оюуны өмчийн байгууллага нь хүлээн авагч байгууллага болох эрх**

44.1.Монгол Улсын иргэн, эсхүл Монгол Улсад байнга оршин суугчийн гаргасан олон улсын мэдүүлгийг хүлээн авагч байгууллага нь Оюуны өмчийн байгууллага байна.

44.2.Оюуны өмчийн байгууллагад гаргах патентын олон улсын мэдүүлгийг холбогдох олон улсын гэрээнд заасан хэлээр үйлдэнэ. Мэдүүлэг гаргагч нь Патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын мэдүүлгийн дамжуулалтын хураамжийг Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын Олон Улсын Товчоонд төлнө.

#### **45 дугаар зүйл.Патентын олон улсын мэдүүлгийг үндэсний үе шатанд гаргах**

45.1.Мэдүүлэг гаргагч нь Монгол Улсыг сонгосон бол давамгайлах огноо тогтоосноос хойш 30 сарын дотор мэдүүлгээ Оюуны өмчийн байгууллагад гаргана. Олон улсын мэдүүлгийг үндэсний үе шатанд мэдүүлэхэд энэ хуулийн 15-21 дүгээр зүйлд заасныг баримтална.

45.2.Мэдүүлэг гаргагч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ зүйлийн 45.1-д заасан хугацааг хоцроосон бол Оюуны өмчийн байгууллагад хугацаа сунгуулах тухай хүсэлт гаргаж болно.

45.3.Мэдүүлэг гаргагч нь энэ зүйлийн 45.1-д заасан хугацааны дотор патентын олон улсын мэдүүлгийг Оюуны өмчийн байгууллагад мэдүүлээгүй, эсхүл энэ зүйлийн 45.2-т заасны дагуу хугацааг сунгаагүй бол Монгол Улсад үндэсний үе шатанд мэдүүлэх эрхээ алдана.

### **ДОЛООДУГААР БҮЛЭГ ПАТЕНТЫН ЭРХ, ПАТЕНТ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ**

#### **46 дугаар зүйл.Зохион бүтээгч, патент эзэмшигчийн эрх**

46.1.Зохион бүтээгч дараахь эрх эдэлнэ:

46.1.1.патентын мэдүүлэг гаргах, патент эзэмших;  
46.1.2.патентын мэдүүлэг гаргахэрхээ бусдад шилжүүлэх;  
46.1.3.патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын ашиглалтаас төлбөр авах.

46.2.Патент эзэмшигч дараахь эрх эдэлнэ:

46.2.1.патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг бусдад лицензийн гэрээгээр ашиглуулах;

46.2.2.патент эзэмших эрх шилжүүлэх;

46.2.3.патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг бусад этгээд зөвшөөрөлгүй ашиглахаас хамгаалуулах;

46.2.4.патентын эрх зөрчсөнтэй холбогдон үүссэн хохирлыг арилгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах.

#### **47 дугаар зүйл.Патентаар олгогдох эрх**

47.1.Патент нь патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, эсхүл бүтээгдэхүүний загварыг патент эзэмшигчээс бусад этгээд зөвшөөрөлгүйгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглахаас хамгаална.

47.2.Патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг ашиглах гэдэгт дараахь зүйл хамаарна:

47.2.1.патентаар хамгаалагдсан, эсхүл патентаар хамгаалагдсан аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, худалдах санал гаргах, худалдах, хэрэглэх, эсхүл энэ зорилгоор хадгалах;

47.2.2.патентаар хамгаалагдсан аргыг хэрэглэх.

#### **48 дугаар зүйл.Патентын эрхийн зөрчилд тооцохгүй байх онцгой нөхцөлүүд**

48.1.Патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар ашигтай загварыг дараахь байдлаар ашиглавал эрх эзэмшигчийн онцгой эрхийг зөрчсөн гэж үзэхгүй:

48.1.1.патент эзэмшигч өөрөө, эсхүл түүний зөвшөөрөлтэйгээр бусад этгээд тус улсын зах зээлд гаргасан бүтээгдэхүүнийг ашиглах;

48.1.2.эрдэм шинжилгээ, сургалт, туршилтын ажилд ашиглах;

48.1.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт түр орж ирсэн бусад орны тээврийн хэрэгсэлд ашиглах;

48.1.4.ашиг олох зорилгогүйгээр ашиглах.

#### **49 дүгээр зүйл.Патентын эрхийг хүчингүйд тооцох**

49.1.Энэ хуульд заасныг зөрчиж олгогдсон патентыг Маргаан шийдвэрлэх зөвлөл, эсхүл шүүх хүчингүйд тооцно.

49.2.Энэ зүйлийн 49.1-д заасны дагуу патентын эрх хүчингүй болсон бол Оюуны өмчийн байгууллага улсын бүртгэлд зохих өөрчлөлт оруулж, албан ёсны тогтмол хэвлэлд нийтэлнэ.

## **50 дугаар зүйл.Шүүхээс авах арга хэмжээ**

50.1.Патентын эрх зөрчсөн гэж үзвэл шүүх бараа, бүтээгдэхүүнийг болон барааг үйлдвэрлэхэд ашигласан түүхий эд, тоног төхөөрөмжийг устгах шийдвэр гаргана.

## **51 дүгээр зүйл.Патентын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах**

51.1.Мэдүүлэг гаргагчийн, эсхүл патент эзэмшигчийн хүсэлтээр патентын улсын бүртгэлд дараахь өөрчлөлт оруулна:

- 51.1.1.мэдүүлэг гаргагчийн, эсхүл патент эзэмшигчийн нэр, хаяг өөрчлөх;
- 51.1.2.патент эзэмшигчийн эрх шилжүүлэх.

51.2.Мэдүүлэг гаргагч, эсхүл патент эзэмшигч нь өөрийн нэр, хаяг өөрчлөгдөхөд, эсхүл патент эзэмшигчийн эрхийг шилжүүлсэн бол ийнхүү өөрчлөлт орсон өдрөөс хойш 6 сарын дотор патентын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлт гаргана. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

51.3.Оюуны өмчийн байгууллага нь улсын бүртгэлд өөрчлөлт оруулсан бол энэ тухай албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлнэ.

## **52 дугаар зүйл.Лицензийн гэрээ**

52.1.Лицензийн гэрээ нь дараахь төрөлтэй байна:

52.1.1.патент эзэмшигч нь патентаар хамгаалагдсан бүтээлээ гуравдагч этгээдэд нэгэн зэрэг ашиглуулахгүй байх нөхцөлөөр байгуулсан онцгой лицензийн гэрээ;

52.1.2.патент эзэмшигч нь патентаар хамгаалагдсан бүтээлээ гуравдагч этгээдэд нэгэн зэрэг ашиглуулахыг хязгаарлаагүй нөхцөлөөр байгуулсан энгийн лицензийн гэрээ.

52.2.Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, хүн амын хүнсний хангамж, эрүүлийг хамгаалах зэрэг нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан патентыг сонирхогч этгээдийн хүсэлтээр Оюуны өмчийн байгууллага патентаар хамгаалагдсан бүтээлийг бусад этгээдэд албадан лицензээр ашиглуулна.

52.3.Патентаар хамгаалагдсан шийдэл ашиглуулах лицензийн гэрээг оюуны өмчийн байгууллагад бүртгүүлнэ. Оюуны өмчийн байгууллага нь лицензийн гэрээ бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор бүртгэж, нийтэд мэдээлнэ.

52.4.Лицензийн гэрээг бүртгүүлэхэд улсын тэмдэгтийн хураамж төлнө.

52.5.Лицензийн гэрээнд дараахь хязгаарлалтыг тогтоосон байж болно:

52.6.1.гэрээний хамрах хүрээ, газар нутгийн ба ашиглах хугацааны хязгаарлалт;

52.6.2.бараа, үйлчилгээний чанарыг сайжруулахад нөлөөлөх нөхцөл;

52.6.3.патент эзэмшигчийн нэр хүндэд, эсхүл патентын эрхэд хохирол учруулахаас зайлсхийх лиценз эзэмшигчийн үүрэг.

52.6.Лицензийн гэрээ нь 52.5-д зааснаас өөрөөр шударга бусаар өрсөлдөх, худалдааг хязгаарлах, эсхүл дарамт үзүүлэх шинжтэй нөхцөлийг агуулсан бол Оюуны өмчийн байгууллага бүртгэхээс татгалзана.

52.7.Лицензийн гэрээг бүртгүүлсний дараа тухайн бүтээлийн патент хүчингүй болсон бол бүртгэгдсэн лицензийн гэрээ хүчингүй болно.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ ОЮУНЫ ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГА**

### **53 дугаар зүйл.Оюуны өмчийн байгууллагын тогтолцоо**

53.1.Оюуны өмчийн байгууллагын тогтолцоо нь оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид “оюуны өмчийн байгууллага” гэх/, оюуны өмчийн хяналтын улсын байцаагч, шинжээчээс бүрдэнэ.

53.2.Оюуны өмчийн байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна.

53.3.Оюуны өмчийн байгууллагын дэргэд патентын эрхийг зөрчсөнөөс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээс бусад өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий Оюуны өмчийн маргаан шийдвэрлэх зөвлөл /цаашид “Маргаан шийдвэрлэх зөвлөл” гэх/ ажиллана.

### **54 дүгээр зүйл.Оюуны өмчийн байгууллагын чиг үүрэг**

54.1.Оюуны өмчийн байгууллага дараахь нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

54.1.1.оюуны өмчийн хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлыг эрх хэмжээний хүрээнд зохион байгуулах;

54.1.2.оюуны өмчийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэх талаар санал боловсруулах;

54.1.3.шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг патентын улсын бүртгэлд бүртгэх, патент олгох, хүчингүй болгох, патентын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах;

54.1.4.оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах этгээдийг шалгаруулах, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

54.1.5.гадаад улс, олон улсын оюуны өмчийн байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах;

54.1.6.албан ёсны тогтмол хэвлэлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах;



54.1.7.эрх шилжүүлэх гэрээ, лицензийн гэрээг бүртгэх, олон нийтэд мэдээлэх;  
54.1.8.оюуны өмчтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай лавлагаа гаргаж өгөх, байгууллага, албан тушаалтнаас холбогдох баримт бичгийг гаргуулж авах;

54.1.9.хуулиар харьяалуулсан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх;  
54.1.10.хууль заасан бусад.

## **55 дүгээр зүйл.Оюуны өмчийн улсын байцаагч**

55.1.Оюуны өмчийн байгууллагад оюуны өмчийн улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллах бөгөөд орон нутагт улсын байцаагч ажиллаж болно.

55.2.Оюуны өмчийн байгууллагын дарга нь оюуны өмчийн улсын ерөнхий байцаагч байна.

55.3.Оюуны өмчийн улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг оюуны өмчийн ерөнхий байцаагч олгоно.

55.4.Оюуны өмчийн улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь оюуны өмчийн хяналт, шалгалтыг гүйцэтгэхдээ оюуны өмчийн хууль тогтоомж, Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

55.5.Улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь улсын ерөнхий байцаагчид ажлаа хариуцан тайлагнах бөгөөд улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр дараахь эрх, үүрэгтэй байна:

55.5.1.хяналт шалгалтын явцад улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, зөрчилтэй баримт бичиг, эд юмсыг акт үйлдэн хураан авч хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх, бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргах, зөрчлийг арилгах талаар холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;

55.5.2.өөрийн хийсэн шалгалт, илрүүлсэн зөрчил, өгсөн албан шаардлага, гаргасан танилцуулга, дүгнэлт, торгох шийтгэлийн үндэслэл, үнэн зөвийг бүрэн хариуцах;

55.5.3.албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцыг задруулахгүй байх.

55.6.Улсын ахлах байцаагч, улсын байцаагч /"цаашид улсын байцаагч" гэх/ нь улсын ерөнхий байцаагчаас баталсан загвар бүхий үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон акт, дүгнэлт, шаардлага, мэдэгдэл хэрэглэнэ.

55.7.Улсын байцаагчийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан заасан хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй.

55.8.Улсын байцаагч хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

55.9.Улсын байцаагчийн шийдвэрийн талаар ерөнхий байцаагчид гомдол гаргах бөгөөд түүний шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

55.10.Оюуны өмчийн улсын байцаагчийн ажиллах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

#### **56 дугаар зүйл.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч**

56.1.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хуульд заасны дагуу оюуны өмчийн байгууллага, шүүх болон эрх бүхий байгууллагад төлөөлүүлэгчийг төлөөлөх эрхтэй байна.

56.2.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй, хуульд заасан шаардлагыг хангасан иргэн, хуулийн этгээд байна.

56.3.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрхийг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно.

56.4.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дээд боловсролтой, оюуны өмчийн салбарт гурваас доошгүй жил ажилласан, ял шийтгэлгүй, 25 насанд хүрсэн Монгол Улсын иргэн байна.

56.5.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах хуулийн этгээд нь 3-аас доошгүй оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй байна.

56.6.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь үйл ажиллагаандаа оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг баримтална.

#### **57 дугаар зүйл.Маргаан хянан шийдвэрлэх**

57.1.Патентын эрхийн асуудлаар дараахь гомдлыг Маргаан шийдвэрлэх зөвлөл хянан шийдвэрлэнэ:

57.1.1.Патентын тухай хуульд заасан үйл ажиллагаатай холбоотой мэдүүлэг гаргагчийн гомдол;

57.1.2.хуульд заасан үндэслэлээр патентын мэдүүлэгт гаргасан гуравдагч этгээдийн эсэргүүцэл;

57.1.3.бүртгэгдсэн патентын эрхийг хуульд заасан үндэслэлээр хүчингүйд тооцуулах тухай хүсэлт;

57.1.4. хуульд заасан бусад.

57.2.Энэ зүйлийн 57.1.1-д заасан гомдлыг мэдүүлэг гаргагч мэдэгдэл хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Маргаан шийдвэрлэх зөвлөлд гаргана.

57.3.Энэ зүйлийн 57.1.2-т заасан эсэргүүцлийг патентын мэдүүлэг анх хэвлэгдсэн өдрөөс хойш 3 сарын дотор Маргаан шийдвэрлэх зөвлөлд гаргана.

57.4.Энэ зүйлийн 57.1.3-т заасан хүсэлтийг патент олгогдсон шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патентын мэдээлэлд хэвлэгдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор Маргаан шийдвэрлэх зөвлөлд гаргана.

57.5.Маргаан шийдвэрлэх зөвлөл нь энэ зүйлийн 57.1-д заасан гомдол, эсэргүүцэл, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 3 сарын дотор хянан шийдвэрлэж, хариуг бичгээр мэдэгдэнэ.

57.6.Холбогдох этгээд Маргаан шийдвэрлэх зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

57.7.Маргаан шийдвэрлэх зөвлөлийн ажиллах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

57.8.Маргаан шийдвэрлэх зөвлөлийг бүх гишүүдийн дийлэнх олонхын ирцтэйгээр хуралдуулах бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

57.9.Маргаан шийдвэрлэх зөвлөл нь шинжээч, улсын байцаагчийн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох, эсхүл хэвээр үлдээх шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

57.10.Маргаан шийдвэрлэх зөвлөлийн тогтоолыг оюуны өмчийн байгууллагын дарга хянаж, тушаалаар баталгаажуулна.

57.11.Оюуны өмчийн байгууллагын дарга Маргаан шийдвэрлэх зөвлөлийн тогтоолыг үндэслэлгүй гэж үзвэл өөрчлөх, эсхүл хүчингүй болгоно.

57.12.Маргаан шийдвэрлэх зөвлөл нь маргаан үүссэн шалтгаан, түүний нөхцөлийг арилгуулах, түүнчлэн патентын хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж гаргах эрхтэй.

## **58 дугаар зүйл.Оюуны өмчийн байгууллагын санхүүжилт**

58.1.Оюуны өмчийн байгууллагын үйл ажиллагааны тодорхой хэсгийг байгууллагын үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжүүлж болох бөгөөд бусад үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

58.2.Энэ хуульд заасан оюуны өмчийн байгууллагын үйлчилгээний хөлсийг Засгийн газар батална.

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **59 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

59.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

59.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

## **60 дугаар зүйл.Хуулийг буцаан хэрэглэх**

60.1.Энэ хуулийг буцааж хэрэглэхгүй.

Гарын үсэг